



The AMERICAN CHAMBER of Commerce in Mongolia

Хэвлэлийн мэдээ:

23.10.2019

Холбоо барих:

+976 9511 7771

АмЧам Монгол экспортыг нэмэгдүүлэх боломж, тулгарч буй сорилтын талаар хэлэлцүүлэг өрнүүллээ

УЛААНБААТАР, Монгол улс – Америкийн худалдааны танхим (АмЧам Монгол) 10-р сарын бизнес уулзалтаа "Экспортын боломжуудыг ашиглах арга замууд" гэсэн сэдвээр 2019 оны 10-р сарын 22-ны Мягмар гарагт Blue Sky зочид буудалд зохион байгууллаа.

Монгол Улсын эдийн засаг нь уламжлалт мал аж ахуй, газар тариалан дээр тогтдог байсан бол гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж, уул уурхайд түшиглэсэн эдийн засагтай болж тэлсэн билээ. Монгол улс зэс, алт, нүүрс, молибден, жонш, уран, цагаан тугалга, вольфрамын асар их нөөцтэй. Уул уурхайн арвин нөөцөөс гадна мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, тухайлбал мах, цагаан идээ, ноос ноолуур, газар тариалангаас гаралтай чацаргана, самар, улаан буудай гэх мэт түүхий болон боловсруулсан бүтээгдэхүүн экспортлох боломжууд болон тулгарч буй сорилтын талаар энэ удаагийн уулзалтаар дэлгэрэнгүй ярилцлаа. Урилгаар оролцсон илтгэгч нар экспорт, импортын өнөөгийн байдал, тулгарч буй бэрхшээл, цаашдын төлөвлөгөө, үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч, өөрсдийн санал бодлоо хуваалцаж сонирхолтой хэлэлцүүлэг өрнүүллээ. Уулзалтад АмЧам Монголын гишүүн компаниуд, гадаадын хөрөнгө оруулагчид, олон улсын банк, санхүүгийн байгууллагын болон Монгол дахь элчин сайдын яамдын төлөөлөгчид оролцож сонирхсон асуултандаа хариулт авлаа.

Монгол Улс 2018 онд нийт 156 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 12.9 тэрбум ам.долларт хүрэв. Үүнээс экспорт 7.0 тэрбум, импорт 5.9 тэрбум ам доллараар хэмжигдэж байна. Экспортын зах зээлийг төрөлжүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газар чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах бодлого хэрэгжүүлж байгаа боловч ариун цэвэр, эрүүл ахуй, гарал үүслийн гэрчилгээ, тээвэрлэлт зэрэг тарифын бус болон тарифын олон тооны асуудал экспортыг нэмэгдүүлэхэд саад болж байгаа билээ.

Европын Холбоо нь жижиг эдийн засагтай, далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын худалдаанд учирч байгаа бэрхшээл, хөгжлийн хэрэгцээ шаардлагыг дэмжих чиглэлээр худалдааны бодлого явуулдаг бөгөөд Европын Холбооны санхүүжилттэй Монголын худалдааг дэмжих төсөл (EU-TRAM) 2017 оны 3-р сараас хэрэгжиж эхэлсэн юм. Хэлэлцүүлгийн панелист Монголын худалдааг дэмжих төслийн хувийн хэвшлийн салбарын ахлах мэргэжилтэн Карл Крунг хэлэхдээ төсөл нь эдийн засгийн бүтцийг төрөлжүүлж, бүтээгдэхүүний үнээс

хамааралтай байдлыг бууруулж төлбөрийн тэнцлийн дарамтыг багасгах гэсэн стратегийн бодлогыг хэрэгжүүлж улмаар Монгол улсын экспортыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулж буйгаа цохон тэмдэглэв.

Гадаад харилцааны яамны Эдийн засгийн хамтын ажиллагаа, гадаад худалдааны газрын орлогч дарга панелист Ганболдын Өлзийсайхан хэлэхдээ, "Монгол Улсын Засгийн газар уул уурхайн бус салбаруудын экспортыг нэмэгдүүлснээр эдийн засгийн өсөлт, хөгжлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлж тусгайлан Монгол экспорт хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа" гэв.

АНУ-ын Элчин сайдын яамны Эдийн засаг, худалдааны хэлтсийн дарга Бэнжамин Ли Роё АНУ-ын Хөнгөлөлтийн Ерөнхий Системийг (GSP) танилцуулж Монголын экспортлогч нарт АНУ руу экспортоо нэмэгдүүлэх боломжийн талаар мэдээлэл өгөв. GSP нь 120 гаруй нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнийг гаалийн татвараас чөлөөлдөг механизм юм.

Хэлэлцүүлгийн модератор Bloomberg TV Mongolia-ийн Гүйцэтгэх захирал Эрдэнэбаатарын Долгион хурц, чиглүүлсэн асуултууд асууж хэлэлцүүлгийг сонирхолтой болгов. Долгион захирал экспортыг дэмжих нь өөрөө цогц асуудал бөгөөд олон талын хүчин чармайлтыг шаарддаг. Мөн манай улс сайн засаглал, тогтвортой хөгжлийн бодлого, хөрөнгө оруулагчдын итгэлийг даах чадвартай байснаар бид өөр улсуудтай эдийн засгийн харилцаагаа өргөжүүлэх боломж нээгдэнэ гэв.

АмЧам Монголын тухай

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.